

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 61 дүгээр тэмдэглэлд:

“XXIII.3. Хүний хөгжил сангаас хүүхдийн мөнгө олгох ажлын явцын талаар Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэ Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээг авч ажиллахыг холбогдох сайд, дарга нарт даалгав:

3.1. Хүүхдийн мөнгө олгох ажлыг эрчимжүүлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд С.Эрдэнэд;

3.2. 2012 оны 10 дугаар сард хүүхдийн мөнгө олгоход шаардагдах хөрөнгийг Монголбанк дахь Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын хүүхдийн мөнгөний тусгай дансанд 10 дугаар сарын 17-ны дотор бүрэн шилжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд;

3.3. Иргэний цахим үнэмлэхийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны дотор харьяа хэлтсүүдээр дамжуулан иргэдэд олгох арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэхийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Ц.Пүрэвдоржид.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр


Дугаар 86

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

“Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 237 дугаар тогтоолын хавсралтын 2.1-д “Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, дахин олгох-10000 төгрөг” гэснийг “Монгол Улсын иргэний үнэмлэх олгох, дахин олгох-15000 төгрөг” гэж өөрчилсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

Н.АЛТАНХУЯГ

Хууль зүйн сайд

Х.ТЭМҮҮЖИН

